



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 16

Мөрөн сум

“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн
жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлт Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын
тайлангийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.13, 8.5.15 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XVIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор өгсөн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

2.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнг “хангалттай” гэж дүгнэсүгэй.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ